12	3.1.01.1.2 Татварын бус орлого	970,768,900.00	1,037,102,703.75
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	54,728,500.00	122,640,584.75
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	20,000,000.00	71,845,000.00
120004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	26,728,500.00	50,071,447.81
120010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	8,000,000.00	-
120009	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	-	724,136.94
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	799,662,400.00	799,662,400.00
122003	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	799,662,400.00	799,662,400.00
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	116,378,000.00	114,799,719.00
123002	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	116,378,000.00	114,799,719.00

II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,914,744,000.00	1,813,234,004.62
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,563,152,800.00	1,514,029,048.90
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,533,272,500.00	1,486,250,918.30
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	892,535,700.00	891,488,709.43
210101	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	835,115,600.00	545,683,950.51
210102	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	-	309,202,075.04
210104	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	20,988,100.00	25,659,480.45
210105	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	36,432,000.00	10,943,203.43
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,566,800.00	110,147,614.99
210201	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	75,865,500.00	74,921,566.78
210202	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	8,925,300.00	8,791,077.74
210203	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	4,462,700.00	4,451,376.14
210204	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	4,462,700.00	4,442,976.84
210205	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	17,850,600.00	17,540,617.49
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	374,050,900.00	365,827,030.88
210301	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	63,790,300.00	51,660,080.03
210302	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	306,366,600.00	311,042,300.85
210303	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	3,894,000.00	3,124,650.00
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	30,633,600.00	25,246,910.00
210401	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	3,256,500.00	1,482,000.00
210402	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	20,709,100.00	18,543,290.00
210403	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,872,500.00	3,114,120.00
210405	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,422,000.00	1,570,000.00
210406	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,373,500.00	537,500.00
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	2,177,500.00	1,000,000.00
210503	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,177,500.00	1,000,000.00
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	20,431,100.00	21,510,796.00
210601	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	5,750,000.00	5,164,700.00
210604	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	14,681,100.00	16,346,096.00
2107	3.1.01.2.1.1.7 Томилот, зочны зардал	22,564,300.00	17,667,800.00
210702	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилот	22,564,300.00	17,667,800.00
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,193,700.00	7,331,517.00
210801	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,586,900.00	33,200.00
210802	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	547,000.00	547,000.00

210803	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	437,500.00	168,600.00
210804	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	535,500.00	494,955.00
210805	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношилгоо	308,000.00	33,000.00
210806	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,778,800.00	5,579,000.00
210807	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	2,000,000.00	475,762.00
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	67,118,900.00	46,030,540.00
210901	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	52,245,800.00	36,938,840.00
210902	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,873,100.00	9,091,700.00
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,880,300.00	27,778,130.60
2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	29,880,300.00	27,778,130.60
213208	3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,630,000.00	27,628,130.60
213209	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,250,300.00	150,000.00
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	170,000,000.00	126,130,555.72
223001	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	170,000,000.00	126,130,555.72
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	181,591,200.00	173,074,400.00
230001	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	181,591,200.00	173,074,400.00
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	280,197,600.00	-142,519,297.25
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-280,197,600.00	142,519,297.25
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-280,197,600.00	142,519,297.25
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	364,565,225.18
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	222,045,927.93
6	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	60	60
61	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	6.1.01 Төсвийн байгууллага	2	2
62	6.2 АЖИЛЛАГСДЫН ТОО	29	29
620001	6.2.01 Удирдах ажилтан	8	8
620002	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	11	11
620003	6.2.03 Үйлчлэх ажилтан	3	3
620004	6.2.04 Гэрээт ажилтан	7	7
65	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29	29
650001	6.5.01 Төрийн захиргааны албан хаагч -ТЗ	10	10
650009	6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч -ТҮ	8	8
650010	6.5.10 Гэрээт ажилтан	4	4
650011	6.5.11 Улс төрийн албан хаагч -УТ	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,617,240.00
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,617,240.00
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	8,617,240.00
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	8,617,240.00
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	8,617,240.00
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,617,240.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,893,103.06
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	7,893,103.06
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,893,103.06
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,890.00
210201	1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал	78,890.00
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	7,477,040.00
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	7,477,040.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	259,653.06
210804	1.1.1.2.1.1.8.4 Тээврийн хэрэгслийн татвар	259,653.06
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	77,520.00
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	77,520.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	724,136.94
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-724,136.94
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-724,136.94

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төрийн захиргааны байгууллагын манлайллыг дээшлүүлж, Төрийн албаны шинэчлэлийг гүнзгийрүүлж, хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хөгжлийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон;
- ✓ Төрийн албаны тухай хуульд – 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр;
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам";
- ✓ Төсвийн тухай хуульд - 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нэгтгэл тайланд хамрагдсан байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,792.0 сая төгрөг болж, өмнөх оноос 154.2 сая төгрөгөөр буюу 5.2 хувиар буурсан байна.

Хүснэгт . Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б		2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	364.6	222.0	-142.6
Авлага	71.8	228.1	156.3
Бараа материал	299.9	173.7	-126.2
Үндсэн хөрөнгө	2,209.9	2,168.2	-41.7
Нийт хөрөнгө	2,946.2	2,792.0	-154.2
Өр төлбөр	2.1	79.9	77.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,944.1	2,712.1	-232.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,946.2	2,792.0	-154.2

Эх сурвалж: Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

3.4. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 222.0 сая төгрөг болж, өмнөх оноос 142.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	364.6	222.0	-142.6
Дүн	364.6	222.0	-142.6

Эх сурвалж: Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 222.0 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Хоршоо хөгжүүлэх сан 3.4 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 81.1 сая төгрөг, Орон нутгийн ерөнхий орлого 137.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 228.1 сая төгрөг болж, өмнөх оноос 156.3 сая төгрөгөөр өссөн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	0.00	0.00	0.00
Зээлийн хүүгийн авлага	0.63	0.63	0.00

Хувь хүмүүсээс авах авлага	8.04	8.04	0.00
Байгууллагаас авах авлага	7.79	7.79	0.00
Хувь хүмүүст олгосон зээл	55.39	211.65	156.26
Дүн	71.85	228.11	156.26

Эх сурвалж: Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 173.7 сая төгрөг болж, өмнөх оноос 126.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Бичиг хэргийн материал	0.1	0.1	0.00
Аж ахуйн материал	151.5	118.9	-32.6
Бусад хангамжийн материал	132.4	38.8	-93.6
Мал амьтад	15.9	15.9	0.00
Дүн	299.9	173.7	-126.2

Эх сурвалж: Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,168.2 сая төгрөг болж, өмнөх оноос 41.7 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдэлтэй холбоотой байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Биет хөрөнгө	1,971.3	1,923.8	-47.5
Барилга, байгууламж, орон сууц	1,319.3	1,418.0	98.7
Хуримтлагдсан элэгдэл	-262.6	-324.1	-61.5
Авто-тээврийн хэрэгсэл	429.4	379.7	-49.7
Хуримтлагдсан элэгдэл	-178.2	-169.4	8.8
Машин тоног төхөөрөмж -компьютер	322.3	320.2	-2.1
Хуримтлагдсан элэгдэл	-135.3	-144.8	-9.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	146.4	118.4	-28.0
Хуримтлагдсан элэгдэл	-85.6	-69.6	16.0
Зам, гүүрийн байгууламж	415.6	415.6	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-28.3	-51.3	-23.0
Бусад үндсэн хөрөнгө	65.0	73.0	8.0
Хуримтлагдсан элэгдэл	-38.1	-43.2	-5.1
Ном	1.3	1.3	0.0
Биет бус хөрөнгө	238.6	244.3	5.7
Программ хангамж	2.9	7.9	5.0
Хуримтлагдсан элэгдэл	-2.9	-4.0	-1.1
Бусад биет бус хөрөнгө	238.6	240.4	1.8
Дүн	2,209.9	2,168.2	-41.7

Эх сурвалж: Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

3.4.5 Өр төлбөр

Тайлант оны эхэнд өр төлбөрийн данс 2.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол тайлант оны эцэст байгууллагад 79.9 сая төгрөг, ажилчидтай холбоотой 0.4 сая төгрөг, байгууллагад төлөх өглөг 78.3 сая төгрөг, татварын өглөг 1.2 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Ажилчидтай холбоотой өглөг	0.0	0.4	0.4
Байгууллагад төлөх өглөг	0.3	78.3	78.0
Хувь хүмүүст төлөх өглөг	1.8	0.0	-1.8
Татварын өглөг /ТӨҮГ/	0.0	1.2	1.2
Дүн	2.1	79.9	77.8

Эх сурвалж: Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,712.1 сая төгрөг болж, өмнөх оноос 231.9 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,016.6	1,016.6	0.0
Хуримтлагдсан үр дүн	1,639.7	1,407.8	-231.9
Өмнөх үеийн үр дүн	1,320.6	1,639.7	319.1
Тайлант үеийн үр дүн	319.1	-231.9	-551.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	287.8	287.8	0.0
Дүн	2,944.1	2,712.1	-231.9

Эх сурвалж: Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

3.4.7 Орлогын данс

Тайлант онд Ховд суманд татварын орлого 633.6 сая төгрөг, татварын бус орлого 1,037.1 сая төгрөг, нийт 1,670.7 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

3.4.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 39.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

Аудитын илрүүлэлт:

Ховд сумын Засаг даргын Тамгын газар:

- ✓ Аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс Увс аймгийн 100 жилийн ойд зориулан өгсөн 39.2 сая төгрөгийн хандивыг Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авсан байна. Цаашид Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно”, 25.2.1 дэх заалтад “Эмнэлгийн үйлчилгээ”, 25.2.2 дахь заалтад “Бүх шатны боловсролын үйлчилгээ”, 25.2.3 дахь заалтад “Соёлын

үйлчилгээ”, 25.2.4 дэх заалтад “Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх”, 25.7 дахь хэсэгт “Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгсөн.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5. Төсвийн төлөвлөлт

Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,808.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Ховд сумын 2025 оны төсвийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 сарын 19-ний өдрийн 2/04 дүгээр тогтоолоор 2,282.8 сая төгрөгөөр баталж, 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 5/03 дугаар тогтоолоор тодотгол хийж, анх баталсан дүнгээс 368.1 сая төгрөгөөр бууруулж, 1,914.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,914.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,562.4 сая төгрөгийг урсгал зардалд, 170.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 182.3 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр 114.8 сая төгрөгийг ОНХСангаас, 1,505.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 50.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, нийт 1,670.7 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,813.2 сая төгрөг буюу 94.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 2.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6.6 сая төгрөг, нийт 8.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 7.9 сая төгрөгийг зарцуулж 0.7 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Ариунсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,326.7 сая төгрөгийн 1 хувиар буюу 33.3 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 26.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,532.3 сая төгрөгийн 1 хувиар буюу 35.3 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 28.3 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 142, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 3 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрлээ.

Ховд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 3.9 сая төгрөгийн цахилгаан эрчим хүчний төлбөр төлсөн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно", 60.3.1 дэх заалтад "Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ", Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт "Сум, дүүргийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ", 4.3.7 дахь заалтад "Сум, дүүргийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах", 4.3.8 дахь заалтад "ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болох хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний өмчлөл, цаашдын ашиглалтын урсгал зардал, шинээр бий болох орон тоог орон нутаг өөрөө хариуцах", 4.4 дэх хэсэгт "Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5. Завсрын аудитын талаар

Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд зөвлөмж өгсөн байна. Аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжсэн бөгөөд Ховд сумын Засаг даргын орлогчийн 57 дугаар албан бичгээр биелэлтийг ирүүлсэн байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0.0	1	0.0	100.0%
Нийт дүн	1	0.0	1	0.0	100.0%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Увс аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/16 дугаар захирамжаар Ховд сумын Засаг даргын Тамгын газрыг 17 орон тоотойгоор баталсан байна. Ховд сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/02 тушаалаар Ховд сумын Засаг даргын Тамгын газрын орон тоог 5 гэрээт ажилтнаар нэмэгдүүлэн баталсан байна. Тоймлон дурдвал, слесарь болон 1 сахиулыг төрийн үйлчилгээний албан тушаалын цалин хөлсөөр, 3 багийн сахиулыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулан нийт 63.7 сая төгрөгийн цалин хөлс олгосон байна. Дараагийн аудитаар бүтэц, орон тоог нягтлан шалгах нь зүйтэй гэж үзсэн.

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн 2 төсвийн байгууллага, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 1 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгч, харьяа 1 байгууллага, 2 санг түүвэрт хамруулсан.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 39.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс:							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗДТГ	1	39.2							1	39.2
2	ИТХ										
Нийт дүн		1	39.2							1	39.2

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 37.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 34.0 төгрөгийн 1 алдааг залруулж, 3.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өглөө.

Залруулсан алдаа:

Ховд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс бэлтгэсэн 34.0 сая төгрөгийн өвсийг сумын Засаг даргын Тамгын газар, Орон нутгийн хөгжлийн сан дээр давхардуулан бараа материалд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг

баримтална”, 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.3 дахь заалтад “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4 дахь заалтад “Нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” болон Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулга хийлгэлээ.

5.1 Албан шаардлага

Ховд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 3.9 сая төгрөгийн цахилгаан эрчим хүчний төлбөр төлсөн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.1 дэх заалтад “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ”, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт “Сум, дүүргийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ”, 4.3.7 дахь заалтад “Сум, дүүргийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах”, 4.3.8 дахь заалтад “ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болох хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний өмчлөл, цаашдын ашиглалтын урсгал зардал, шинээр бий болох орон тоог орон нутаг өөрөө хариуцах”, 4.4 дэх хэсэгт “Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ховд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс бэлтгэсэн 34.0 сая төгрөгийн өвсийг сумын Засаг даргын Тамгын газар, Орон нутгийн хөгжлийн сан дээр давхардуулан бараа материалд тусгасан	1	34.0			1	34.0	1	34.0				
Нийт дүн	1	34.0			1	34.0	1	34.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байхгүй												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Байхгүй												

Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ховд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 3.9 сая төгрөгийн цахилгаан эрчим хүчний төлбөр төлсөн байна.	1	3.9			1	3.9		
Дүн	1	3.9			1	3.9		
Нийт дүн	1	3.9			1	3.9		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Г.АРИУНСАЙХАН/

2026.03.24